A large, 3D, metallic bank logo is mounted on the facade of a modern building with a glass and stone exterior. The logo consists of a stylized circular emblem with a central vertical element. The background shows the building's architecture and a clear sky.

# БАНКНЫ САЛБАРЫН ӨНӨӨГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ, БОДЛОГЫН ЗОРИЛТУУД

МОНГОЛБАНК  
2023 ОНЫ 2 ДУГААР УЛИРЛЫН БАЙДЛААР




ТООН ҮЗҮҮЛЭЛТҮҮД



1

# БАНКНЫ САЛБАРЫН ЗАРИМ ТООН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

## 2023 оны 02 дугаар улирлын байдлаар




### Эрсдэлийн сангийн хүрэлцээ




# БАНКНЫ САЛБАРЫН ЗАРИМ ТООН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

## 2023 оны 02 дугаар улирлын байдлаар


АКТИВЫН ҮЛДЭГДЭЛ, ӨСӨЛТ, ИХ НАЯД ТӨГРӨГӨӨР



АКТИВЫН БҮТЭЦ, ИХ НАЯД ТӨГРӨГӨӨР



АКТИВЫН ЖИЛИЙН ӨСӨЛТ, ХУВИАР




Эх сурвалж: ББӨБГ, Монголбанк


# БАНКНЫ САЛБАРЫН ЗАРИМ ТООН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

## 2023 оны 02 дугаар улирлын байдлаар


ЭХ ҮҮСВЭРИЙН ҮЛДЭГДЭЛ, ӨСӨЛТ, ИХ НАЯД ТӨГРӨГӨӨР



ЭХ ҮҮСВЭРИЙН БҮТЭЦ, ИХ НАЯД ТӨГРӨГӨӨР



ЭХ ҮҮСВЭРИЙН ЖИЛИЙН ӨСӨЛТ, ХУВИАР




Эх сурвалж: ББӨБГ, Монголбанк

# БАНКНЫ САЛБАРЫН ЗАРИМ ТООН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

## 2023 оны 02 дугаар улирлын байдлаар


ЗЭЭЛИЙН ҮЛДЭГДЭЛ, ӨСӨЛТ, ИХ НАЯД ТӨГРӨГӨӨР




ЗЭЭЛИЙН ҮЛДЭГДЭЛ (САЛБАРААР)



ЗЭЭЛИЙН ЖИЛИЙН ӨСӨЛТ (ДҮНГЭЭР)



ЗЭЭЛИЙН ЖИЛИЙН ӨСӨЛТ (ХУВИАР)



# БАНКНЫ САЛБАРЫН ЗАРИМ ТООН ҮЗҮҮЛЭЛТҮҮД


## 2023 оны 02 дугаар улирлын байдлаар

ЧАНАРГҮЙ ЗЭЭЛИЙН ҮЛДЭГДЭЛ  
(САЛБАРААР, ТЭРБУМ ТӨГ.)




**2,060.2 тэрбум төгрөг** НИЙТ ЧАНАРГҮЙ ЗЭЭЛ

ЧАНАРГҮЙ ЗЭЭЛИЙН ЖИЛИЙН ӨСӨЛТ  
(ДҮНГЭЭР, ТЭРБУМ ТӨГ.)




**135.6 тэрбум төгрөг** ЧАНАРГҮЙ ЗЭЭЛ ӨСӨЛТ

ЧАНАРГҮЙ ЗЭЭЛИЙН ЖИЛИЙН ӨСӨЛТ  
(ХУВИАР)



**7%** ЧАНАРГҮЙ ЗЭЭЛИЙН ЖИЛИЙН ӨСӨЛТ

A large, 3D, metallic logo of a bank is mounted on the facade of a modern building with large glass windows. The logo consists of a stylized, circular emblem with a central vertical element. The building's facade is made of light-colored stone or concrete panels.

# НӨХЦӨЛ БАЙДАЛ: БАНКНЫ САЛБАР ДАХЬ БОДЛОГЫН ЗОРИЛТУУД

2



## БАНКНЫ САЛБАРЫН ДУНД ХУГАЦААНЫ ШИНЭТГЭЛИЙН ХӨТӨЛБӨР /2020-2023/

### ЗОРИЛГО:

“Уг хөтөлбөрийг хэрэгжүүлснээр нэг талаас банкны салбарын өөрийн хөрөнгө нэмэгдэн эрүүлжиж, эрсдэл даах чадвар сайжирч, өмчлөл нь олон улсын жишгийн дагуу **ОЛОН НИЙТИЙН ӨМЧИЙН ХЭЛБЭРТ ШИЛЖИЖ**, банкуудад тавих хөндлөнгийн хяналт нэвтэрч, үйл ажиллагаа нь ил тод тунгалаг болж, зохистой засаглалын гол хүчин зүйл болох шийдвэр гаргах, гүйцэтгэх, хяналт тавих эрх мэдэл хуваагдаж, **ХАРИЛЦАН БИЕ БИЕДЭЭ ХЯНАЛТТАЙ, ТЭНЦВЭРТЭЙ ЭРХ МЭДЭЛТЭЙ** байх зарчим бий болж, дотоод хяналтын тогтолцоо хангагдана; нөгөө талаас олон улсын стандарт, сайн туршлагад нийцсэн зохицуулалтын эрх зүйн орчин бүрдэж, **ЭРСДЭЛД СУУРИЛСАН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫГ** нэвтрүүлнэ; эдгээрийн үр дүнд гадаад дотоодын хөрөнгө оруулагч нарын **БАНКАНД ИТГЭХ ИТГЭЛ НЭМЭГДЭЖ**, санхүүгийн зуучлал өргөжин гүнзгийрч, улмаар банкны систем эдийн засгийн урт хугацааны тогтвортой, хүртээмжтэй эерэг өсөлтөд зохих хувь нэмрээ оруулах болно.”

# ЗОРИЛТУУД

1

Банкны зохистой засаглалыг сайжруулах орчныг бүрдүүлэх

2

Хяналт шалгалт, зохицуулалтыг олон улсын сайн туршлагатай нийцүүлэх

3

Олон улсын мэргэжлийн байгууллагатай хийх хамтын ажиллагааг үргэлжлүүлэх

4

Мөнгө угаахтай тэмцэх тогтолцооны үр дүнтэй байдлыг нэмэгдүүлэх

5

Банкны зохицуулалтыг үйл ажиллагаа, бизнес загвар зэргийн хүрээнд төрөлжүүлэх

# ШИНЭТГЭЛИЙН ХӨТӨЛБӨР: ОНЦЛОХ АЖЛУУД

## Нэг. Банкны зохистой засаглалыг сайжруулах орчныг бүрдүүлэх /80% биелэлттэй/

- Системд нөлөө бүхий банкныг нээлттэй ХК хэлбэрээр өөрчлөн байгуулах, IPO-той холбоотой журам заавар боловсруулах;
- Бусад банкныг хувьцаат компани хэлбэрээр өөрчлөн байгуулах, холбогдох журам заавар боловсруулах;
- Банкны зохистой засаглалыг хэрэгжүүлэх, хяналт тавих журмыг сайжруулах;
- Банкны хувь эзэмшлийн төвлөрлийг 20 хувь хүртэл бууруулах эрх зүйн орчныг бүрдүүлэх, хэрэгжилтэд хяналт тавих.

# IPO

Гурав. О/У-н мэргэжлийн байгууллагатай хийх хамтын ажиллагааг үргэлжлүүлэх /100% биелэлттэй/



Дөрөв. Мөнгө угаахтай тэмцэх тогтолцооны үр дүнтэй байдлыг нэмэгдүүлэх /100% биелэлттэй/

## Хоёр. Хяналт шалгалт, зохицуулалтыг олон улсын сайн туршлагатай нийцүүлэх /80% биелэлттэй/

- СТОУС 9-г нэвтрүүлэх, холбогдох журам заавар боловсруулах;
- RBS/ICAAP/ILAAP/SRP-г нэвтрүүлэх, холбогдох журам заавар боловсруулах;
- Зээлийн үйл ажиллагаа, барьцаа хөрөнгийн үнэлгээ, албадлагын арга хэмжээ зэрэгтэй холбогдсон харилцааг зохицуулах журам боловсруулах.



## Тав. Банкны зохицуулалтыг үйл ажиллагаа, бизнес загвар зэрэгт тулгуурлан төрөлжүүлэх /70% биелэлттэй/

- Хөрөнгө оруулалтын төрөлжсөн банкны тухай хуулийг батлуулахтай холбогдох ажлуудыг хийж гүйцэтгэх;
- Хөрөнгө оруулалтын төрөлжсөн банкныг үүсгэн байгуулах, татан буулгах, түүний үйл ажиллагааны хэм хэмжээг тодорхойлж, хянан шалгахтай холбогдсон харилцааг зохицуулах журмуудыг боловсруулах.

## Төрөөс мөнгөний бодлогын талаар 2024 онд баримтлах үндсэн чиглэлийн төсөл

### БАНКНЫ САЛБАРЫН ТОГТВОРТОЙ БАЙДЛЫН ХҮРЭЭНД

2.1

Гадаадын банкны бие даасан салбар, нэгжийг дотоодын санхүүгийн салбарт нэвтрүүлж, эх үүсвэрийн зардал багатай, өндөр технологид суурилсан, өрсөлдөх чадвартай бүтээгдэхүүн үйлчилгээг бий болгох замаар санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлж, банкны салбарын тогтвортой өсөлтийг эрчимжүүлнэ.

2.2

Эрсдэлд суурилсан хяналт шалгалтын үнэлгээний цогц аргачлалыг (SREP) нэвтрүүлэн банкууд дотооддоо эрсдэлээ үнэлэх тогтолцоог бүрдүүлэх замаар банкуудын зохистой засаглал, эрсдэлийн удирдлагыг сайжруулж, банкны салбарын тогтвортой байдлыг хангана.

2.3

Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үндэсний хэмжээнд хэрэгжих хөтөлбөр болон үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг ханган ажиллаж, Монгол улсын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх, үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцооны үр дүнтэй байдлыг нэмэгдүүлэх

## Зорилт 2.1

Гадаадын банкны бие даасан салбар, нэгжийг дотоодын санхүүгийн салбарт нэвтрүүлж, эх үүсвэрийн зардал багатай, өндөр технологид суурилсан, өрсөлдөх чадвартай бүтээгдэхүүн үйлчилгээг бий болгох замаар санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлж, банкны салбарын тогтвортой өсөлтийг эрчимжүүлнэ.

# Үндэслэл

Гадаадын банк үйл ажиллагаагаа эрхлэх эрх зүйн орчныг бүрдүүлж эхэллээ.



Эдийн засаг, санхүүгийн салбарт үзүүлэх эерэг нөлөөлөл

- Банкны салбар дахь өрсөлдөөнийг эрчимжүүлнэ.
- Инновац, өндөр технологид суурилсан санхүүгийн бүтээгдэхүүн үйлчилгээний хүртээмж нэмэгдэнэ.
- Хөгжиж буй оронд шаардлагатай хямд өртөг бүхий зээлийн шинэ эх үүсвэр бүрдэж, санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлнэ.
- Банкны засаглал, хянан нийцүүлэлтийн чадавхыг бэхжүүлэхэд эергээр нөлөөлнө.
- Корреспондент төлбөр тооцоо болон худалдааны санхүүжилтийн үйлчилгээний чанар, хүртээмж сайжирна.

# Хэрэгжүүлэх арга хэмжээ

Гадаадын банкны салбар, нэгж үйл ажиллагаагаа явуулах эрх зүйн орчныг бүрдүүлэх хүрээнд:

- Гадаадын банкны салбар, нэгж үйл ажиллагаагаа явуулахад тавигдах нөхцөл шаардлагыг гадаадын банкны харьяалал, өмчлөлийн төрөл, бизнес загварт нь тохируулан нарийвчлан тогтоож, шаардлагатай тохиолдолд холбогдох хууль, журамд өөрчлөлт оруулах;
- Монгол Улсад салбар, нэгжээ байгуулах хүсэлтэй гадаадын банкны улс орны хянан шалгах эрх бүхий этгээдтэй Монголбанк хамтын ажиллагааны гэрээ, харилцан ойлголцлын санамж бичиг байгуулах замаар мэдээлэл солилцох, хамтарсан хяналт, шалгалт хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлэх;

Хөрөнгө оруулалтын төрөлжсөн банкны үйл ажиллагааны нарийвчилсан зохицуулалтыг бий болгох хүрээнд:

- Хөрөнгө оруулалтын төрөлжсөн банкны зээл олгох, үнэт цаас, санхүүгийн хэрэгсэл худалдах, худалдан авах, хязгаарлалт зохистой харьцаа, хяналт шалгалттай холбоотой нарийвчилсан зохицуулалтыг тодорхойлж, холбогдох журмуудыг боловсруулан, батлуулах

## Зорилт 2.2

Эрсдэлд суурилсан хяналт шалгалтын үнэлгээний цогц аргачлалыг (SREP) нэвтрүүлэн банкууд дотооддоо эрсдэлээ үнэлэх тогтолцоог бүрдүүлэх замаар банкуудын зохистой засаглал, эрсдэлийн удирдлагыг сайжруулж, банкны салбарын тогтвортой байдлыг хангана.

### Хяналт шалгалтын үнэлгээний аргачлал (SREP)-ын хүрээнд үнэлэх үндсэн хэсгүүд

1. Бизнес загвар	2. Засаглал ба эрсдэлийн удирдлага	3. Өөрийн хөрөнгийн хүрэлцээний эрсдэл	4. Хөрвөх чадвар, санхүүжилтийн эрсдэл
<ul style="list-style-type: none"><li>Бизнес загварыг үнэлэх</li></ul>	<ul style="list-style-type: none"><li>Зохистой засаглалыг үнэлэх;</li><li>Эрсдэлийн удирдлагын тогтолцоог үнэлэх.</li></ul>	<ul style="list-style-type: none"><li>Зээл, зах зээл, үйл ажиллагаа болон хүүгийн (IRRBB) эрсдэлүүдийг үнэлэх;</li><li>Өөрийн хөрөнгийн хүрэлцээг дотооддоо үнэлэх аргачлал (ICAAP)-ыг үнэлэх;</li><li>Стресс тест хийх.</li></ul>	<ul style="list-style-type: none"><li>Богино хугацааны хөрвөх чадварын эрсдэл болон тогтвортой санхүүжилтийн эрсдэлийг үнэлэх;</li><li>Хөрвөх чадварын хүрэлцээг дотооддоо үнэлэх аргачлал (ILAAP)-ыг үнэлэх;</li><li>Стресс тест хийх.</li></ul>

# Хэрэгжүүлэх арга хэмжээ




Базел стандартын Бүлэг 2-т заасны дагуу банкуудын өөрийн хөрөнгийн хүрэлцээ (ICAAP), хөрвөх чадварын хүрэлцээ (ILAAP)-г дотооддоо үнэлэх аргачлалыг холбогдох журам, зөвлөмжид тусгаж, банкны системд үзүүлэх нөлөө, эрх зүйн орчин зэрэгтэй уялдуулан холбогдох хугацаат төлөвлөгөөний дагуу шат дараатайгаар хэрэгжүүлэх.



Банкуудын хөрвөх чадварыг дотооддоо үнэлэх аргачлал (ILAAP)-ыг Базел стандартын хөрвөх чадварын зохистой харьцааг нэвтрүүлэх хугацаатай уялдуулан хэрэгжүүлэх.



Хяналт шалгалтын үнэлгээний аргачлалыг (SREP) нэвтрүүлэх зорилгоор холбогдох журам, зөвлөмжийг шинэчилж, банкны хянан шалгагч нарыг эрчимжүүлсэн сургалтад хамруулж, чадавхжуулах.




Хяналт шалгалтын үнэлгээний аргачлал (SREP)-ын хүрээнд макро стресс тест, банкуудын богино бөгөөд дунд хугацааны бизнес загварын үнэлгээг гүйцэтгэх.



## Зорилт 2.3

Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үндэсний хэмжээнд хэрэгжих хөтөлбөр болон үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг ханган ажиллаж, Монгол улсын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх, үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцооны үр дүнтэй байдлыг нэмэгдүүлэх




# Хэрэгжүүлэх арга хэмжээ

Үндэсний болон салбарын эрсдэл, стратегийн шинжтэй аюул занал, чиг хандлага, типологийг тогтмол хянаж, өөрчлөлтийг үнэлэх

Хууль тогтоомжийг хэрэгжүүлэх боловсон хүчний чадавхыг бэхжүүлж, мэдээлэх үүрэгтэй этгээд, олон нийтийг соён гэгээрүүлэх ажлыг эрчимжүүлэх

Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээр дотоод болон гадаад хамтын ажиллагааг өргөжүүлэх



Эрсдэлд суурилсан хяналт шалгалтын тогтолцоог бэхжүүлэн, мэдээлэх үүрэгтэй этгээдийн урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг чанаржуулах

Санхүүгийн мэдээллийн албанд ирүүлж буй болон хууль сахиулах байгууллагад шилжүүлж буй тайлан, мэдээллийн тоо, чанар, үр дүнтэй байдлыг сайжруулах арга хэмжээ авах